

ШАРГА СУМД 2019 ОНЫ 3 ДУГААР САРД БОЛСОН  
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2019.03.26

Баянгол

ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙХ АЖЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 40 сая төгрөгийн хөрөнгөөр хийх ажлуудыг 2019.03.18-ны өдөр иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж тодрууллаа. Энэ хүрээнд дараах ажлуудыг санхүүжүүлэхээр боллоо.

1. Эмнэлэгийн тоног төхөөрөмж-13.0 сая \эхo, зүрхний бичлэгийн таблет, даралтны аппарат, зөөврийн компьютер\
2. Сургуульд жүдо бөхийн дэвжээ-5.0 сая
3. Пакерийн нүх хийх-2.0 сая \мал эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгах\
4. 0.4 кВт-ын шугамын өргөтгөл-14.0 сая
5. Түүхийн дурсгалын өвийг хамгаалах, хайсжуулах, хаягжуулах-0.5 сая
6. Рашаан булгийн эх хамгаалах, тохижуулах-3.5 сая



УЛААНТУГ БАГИЙН ИНХ БОЛЛОО

2019.03.21-ний өдөр Улаантуг багийн ИНХ боллоо. Хуралд газрын даамал, санхүү албаны дарга, байгаль орчны байцаагч нар оролцож цаг үеийн ажил, шинэчилсэн хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийлээ. Мөн сумын 2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийх хөтөлбөр арга хэмжээний саналыг иргэдээс авлаа. Татварын орлогыг бүрдүүлэхэд анхаарч хог хаягдлын хураамжийг 9 өрхөөс хураалаа.



## МАРШ ТАКТИКИЙН ТЭМЦЭЭН БОЛЛОО

Монгол цэргийн өдрийг тохиолдуулан сумын ЗДТГ-аас марш тактикийн тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 5 хүний бүрэлдэхүүнтэй 6 баг оролцсоноос 1-р байрыг Х.Төмөрбаатар ахлагчтай баг, 2-р байрыг Б.Шинэхүү ахлагчтай баг, 3-р байрыг С.Занданбилэг ахлагчтай багууд эзэллээ. Энэ үеэр эрчүүдэд шагналыг гардуулж баяр хүргэхийн зэрэгцээ цэргийн албаны тухай хуулиар мэдээлэл хийлээ.



### ЕРӨНХИЙ САЙДЫН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ НИЙТ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИДДАА МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ

Засаг дарга М.Тунгалагтамир Ерөнхий сайдын үүрэг даалгаврыг нийт төрийн албан хаагчиддаа мэдээлж хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг болголоо. Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмээр ДАШБХ мэргэжилтэн Д.Ончимэг сургалт зохион байгууллаа. Сургалт, мэдээлэлд нийт 103 төрийн албан хаагч оролцлоо.



### БӨХӨН ЗЭЭРЭНД ӨВС ТЭЖЭЭЛ ТАВЬЖ ӨГЛӨӨ

Цаг агаар, өвөлжилт хүндэрч байгаа Шарга, Хүйсийн говьд байгаа бөхөн, хар сүүлтэй, цагаан зээр зэрэг амьтаддаа БОАЖГ, ДБХС хамтран өвс, тэжээл, хужир тавьж биотехникийн арга хэмжээг эхлүүллээ.





### ГАЗАР ХӨДЛӨЛТИЙГ ТАНИУЛАХ СУРГАЛТ БОЛЛОО

Бүрэн дунд сургуулийн 3-12 дугаар ангийн сурагчид, багш нарт “Газар хөдлөлт” сэдэвт 1 цагийн сургалтыг орж, газар хөдлөлтийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлаа хэрхэн хангах, газар хөдлөлтийн үед өөрийгөө аюулаас хамгаалах арга хэрэгслийг таниуллаа. Мөн сургуулийн 1-2-р анги, цэцэрлэгийн ахлах бүлгийн сурагчдад “Аврагч мазаалайн тусамж” шторикийг үзүүллээ. Сургалтанд дунд сургуулийн 198 сурагч, 24 багш ажилчид, цэцэрлэгийн ахлах бүлгийн 28 сурагч, 5 багш ажилчид хамрагдлаа.



Цэцэрлэгийн хүүхдүүдэд газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах дадлагыг хийлгэлээ. Газар хөдлөлтийн аюулын тухай мэдлэгээ дээшлүүлэх, аюулаас урьдчилан сэргийлэх, ажиллаж амьдрах орчноо аюулгүй болгох мэдээллийг агуулсан брошурыг 120 ширхгийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд тараалаа.

### **ГАМШГААС ХАМГААЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЛТЫГ ХИЙЛЭЭ**

- 1 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх “Сирень” дохиог 16-00 цагт дуугаргалаа.
2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн анги 16 цаг 20 минутад бэлэн цугларч ирц 80.5 хувьтай байв.
3. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд 2019 онд болох “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн бэлтгэл хангах төлөвлөгөөг танилцуулж, сумын төвд “Газар хөдөлсөн тухай” цагийн байдал өгсөн. Бүрэн дунд сургуулийн дотуур байрын 55 сурагч, 5 ажилтанг сумын төв талбайд /аюулгүй бүсэд/ нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг хийлээ. Сурагчид ажилчдыг бүртгэж, биеийн эрүүл мэндийн үзлэг хийж, сэтгэл заслын тусламж үзүүллээ.



**“ХҮҮХДЭЭ СОНСЪЁ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ДОТУУР БАЙРНЫ СУРАГЧИДТАЙ УУЛЗЛАА.**

2019 оны 3 сарын 19-ний өдөр сумын засаг дарга М.Тунгалагтамир дотуур байрны үйл ажиллагаатай танилцан, багш, ажилчид, сурагчдын санал хүсэлтийг сонсож үүрэг чиглэл өглөө.





## БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

### ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛУУДААС:

Тухайн сард сургалт хүмүүжлийн ажлыг жигд явуулж 716 ор хоногийг биелүүлж ажилласан байна. Ханиад томуу ихтэй байснаас хүүхдийн ирц буурсан.

Анги бүлгүүд хөтөлбөр төлөвлөгөөний дагуу сургалт хүмүүжлийн ажлыг явуулж байгууллагын дотоод хяналтын ажилтан, эрхлэгч нар хоёр бүлгийн хөгжүүлэх үйл ажиллагаан дээр сууж хүүхдүүдийн үйл ажиллагаанд оролцож байгаа байдал, багшийн заах арга барил, сургалт хүмүүжлийн ажилд бэлтгэсэн байдалд хяналт тавьж ажилласан.



Ахлах бүлэг сурагчдын дунд “ Бид том болж байна” сэдэвт буухиа тэмцээн, мөн Олон улсын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ЗДТГ, Сургууль, Соёлын төв, Төрийн банк, ХААН банкны эмэгтэйчүүдэд цэцэгт мэндчилгээ хүргэж баяр хүргэлээ.



Г. Алтанцэцэг багш эцэг эхчүүдэд сургалт явуулж дугуйлангийн хүүхдүүдийн хийсэн бүтээлүүдийг танилцуулж хүүхдийн чадвар, бүтээлч сэтгэлгээнд ахиц гарсныг үнэлж дүгнэсэн байна.



Мөн эцэг эхчүүдэд хялбар аргаар сарнай цэцэг хийх аргыг зааж хамтын бүтээл хийж нийт 13 эцэг эх оролцсон байна.

### **ШАРГА СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХИЙСЭН АЖИЛ:**

2 сарын 25-наас “Эх хэлээ эрхэмлэе” 7 хоногийн аяныг сургалтын менежер Д.Нарантуяа, монгол хэл бичгийн багш Ц.Сайнлхам, Г.Дөлгөөн нар ивээн тэтгэн зохион байгууллаа. Үүний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж, 3 сарын 22-ны өдөр шагналыг гардуулан өглөө.

№	Зохион байгуулсан ажил	Хамрах хүрээ	1-р байр	2-р байр	3-р байр
1	“Алдаагүй бичигтэн” уралдаан	1-5-р анги	П.Гантулга багштай 1а анги	П.Ариунжаргал багштай 5а анги	Н.Ариунбилэг багштэй 3а анги
2	“Миний ээж” сэдвээр шүлгийн уралдаан	6-9-р анги	Б.Оюунгэрэл багштай 8а анги	Л.Хишигбаяр багштай 9а анги	Э.Алтайбаатар багштай 6а анги
3	“Ээждээ хэлэх үг захидлын уралдаан	10-12-р анги	Т.Дандар багштай 10а анги	Г.Дөлгөөн багштай 12а анги	П.Лхагвадулам багштай 11а анги
4	Багш, эцэг эх, сурагч “Бид хамтдаа” танин мэдэхүйн тэмцээн	6-12-р анги	Л.Хишигбаяр багштай 9а анги	Э.Алтайбаатар багштай 6а анги	Г.Дөлгөөн багштай 12а анги

2 сарын 25-3 сарын 04 өдрүүдэд сурагчдын дунд “Байгалийн эмч” гар зургийн уралдааныг СОНОР, ЯНЗАГА эко клубын сурагчид зохион байгууллаа. нийт 56 бүтээл ирснээс шалгарууллаа. 1-5-р ангийн ангилалд 1-р байр Б.Лхагвадорж, 2-р байр



Б.Жадамба, 3-р байр Б.Эрхсаран, 6-12-р ангилалд А.Цэрэн-Очир, Б.Мөнхцож, Бо. Энхсаран нар тус тус байр эзэллээ.



3 сарын 16-ны өдөр Тонхил суманд зохион байгуулагдсан баруун бүсийн үндэсний бөхийн тэмцээнд нийт 15 хүүхэд оролцсноос:


1. 11а ангийн сурагч Б.Дашдаваа 1-р байр
2. 9а ангийн сурагч Б.Эрхбаяр 1-р байр
3. 8а ангийн сурагч Г.Чулуунтогтох 2-р байр
4. 6а ангийн сурагч Б.Мөнхцож 2-р байр
5. 11а ангийн сурагч Ц.Бөхсумьяабазар
6. 5а ангийн сурагч Б.Лхагвадорж 3-р байр
7. 4а ангийн сурагч А.Алтанбагана 3-р байр багийн дүнгээрээ 3-р байр эзэллээ.



Эмэгтэйчүүдийн баяр болон эр цэргийн баярыг тохиолдуулан 4а ангийн багш С.Одмаа ивээн тэтгэн ангийнхаа сурагчдын дунд “бяцхан мисс”, “Аав бид” тэмцээнүүдийн санаачлан зохион байгууллаа.



3 сарын 14-ны өдөр “Хүүхэд хэрэглэгч” сургалтыг зохион байгууллаа. Худалдагч үйлчлүүлэгч гэсэн дүрийн тоглолтыг зохион байгуулж, хүүхдүүд үйлчилгээний байгууллагаар хэрхэн үйлчлүүлдэг, хэрхэн үйлчлүүлэх ёстой, үйлчилгээний соёл, бүтээгдэхүүнээ хэрхэн сонгож авах талаар дүрийн тоглолт зохион байгууллаа.



Сурагчид “Хүүхэд хэрэглэгч” гэж нэрлэсний утга учир болон бүтээгдэхүүн хэрхэн сонгон авах, хугацаа, сав баглаа боодол, орц найрлага, шошго, зааврыг эмчтэй хамтран уншиж сурлаа.



Үйлчилгээний байгууллагын зарлагын самбарт “Хүүхэд хэрэглэгч” мэдээлэл сурталчилгааг байршууллаа.







3 сарын 20-21-ний хооронд боловсролын үнэлгээний төвөөс сургалтын чанарын үнэлгээний судалгааг зохион байгууллаа. Шалгалтын комиссоор БСУГ-ын мэргэжилтэн Н.Жаргалсайхан, багш П.Лхагвадулам нар ажиллалаа. Чанарын үнэлгээний судалгаа нь 9-р ангийн сурагчдад хийгдсэн бөгөөд монгол хэл, математик, англи хэл, физик гэсэн судлагдахуунаар зохион байгуулагдлаа.

Мөн асуулга судалгаа, 5 эцэг эхийн төлөөллөөс судалгаа авах, судлагдахууны судалгаа гэсэн 3 төрөлтэйгээр явагдлаа.

ЭЕШ-2019 сорилго шалгалтыг хуваарийн дагуу авч дүн мэдээг БСУГ-т хүргүүлэв. ЭЕШ-нд сурагчдадаа бэлтгэж байгаа багш нар дүнд анализ хийн ажиллаж байна.

3 сарын 23-нд Алтай хотод зохион байгуулагдсан монгол хэл бичгийн шалгалтанд анги удирдсан багш Г.Дөлгөөн хариуцан, 12-р ангийн сурагчдыг бүрэн хамрууллаа.

3 сарын 21-ны өдөр бага боловсрол сурталчлах ажлын хүрээнд 5а ангийн нэрэмжит дууны тэмцээн зохион байгуулагдлаа. 1-р байр П.Гантулга багштай 1А анги, 2-р байр С.Одмаа багштай 4а анги шалгарлаа.



“Дуулах өв-2019” улсын уралдааны 1-р шатны шалгаруулалтыг 3 сарын 19-ний өдөр зохион байгуулж, 6-9 насны ангилалд 3а ангийн сурагч Б.Балжинням, 10-13 насны ангилалд 5а ангийн сурагч Ш.Анхчимэг, 14-17 насны ангилалд 9а ангийн сурагч Г.Тэргэл нар шалгарлаа. Дуулах өв -2019 улсын уралдааны II-р шатанд

Б.Балжинням, Г.Тэргэл нар оролцож, Г.Тэргэл 1-р байр эзлэн III шатанд оролцохоор боллоо.

Үдийн цайны хяналтын зөвлөл хуралдаж, гурилан бүтээгдэхүүний орц найрлага, хэмжээний хувьд ярилцаж, эцэг эхийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар хуралдлаа. Эмч



Д.Эрдэнэтуяа нийт сурагчдад урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.

Улсын төрөлжсөн олимпиадын II-ын даваанд оролцох багш, сурагчид 3 сарын 24-нөөс эхэлж, хуваарийн дагуу оролцож эхэллээ.

### Соёлын талаар:

2019 оны эмэгтэйчүүдийг баярыг тэмдэглэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2019.02.28-ны өдөр сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл хуралдаж, хэлэлцэн баталсан.

Хийж хэрэгжүүлсэн ажил:

**Нэг. “Сумын 2019 оны Буянтай ээж”** өргөмжлөлт Хамтын хүч багийн өндөр настан **Жамбалын Жогвооны** нэрэмжит **“Гар бөмбөг”**-ийн тэмцээнийг 3 сарын 2-ны 10 цагт сургуулийн заалд хийсэн ба 9 баг тамирчид оролцож эхний 3 байрыг Ж.Жогвоон болон үр хүүхдүүд нь шагнаж урамшуулсан.

1-р байр: Б.Гэрэлцэцэг,  
П.Лхагвадулам, Б.Одончимэг,  
Д.Оюунгэрэл, Б.Гэрэлт-Од, Б.Эрдэнэтуяа

2-р байр: Х.Уранцэцэг,  
П.Бямбадулам, С.Алимаа,  
Б.Болорчимэг, Б.Мөнхчимэг,  
Д.Нарантуяа

3-р байр: Б.Оюунтүлхүүр,  
Д.Наранцэцэг, Б.Баялагмаа,  
С.Долгорсүрэн, Г.Болорцэцэг,  
Э.Болормаа нар тус тус эзэлсэн.





**Хоёр.** 3 сарын 3-ны өдрийн 09 цагт сургуулийн дуу хөгжмийн өрөөнд Канастрын тэмцээнийг нийт бүртгүүлсэн эмэгтэйчүүдийн оролцоотойгоор шагналын санг бүрдүүлэн зохион байгуулсан ба 18 багийн 54 эмэгтэй оролцож нийт 162000 төгрөгийг хураасан.

1-р байр: Г.Ариунаа, Л.Наранцэцэг, С.Долгосүрэн - 60000

2-р байр: Х.Уранцэцэг, Н.Цогзолмаа, Д.Оюунгэрэл - 45000

3-р байр: Л.Оюунбилэг, Б.Баялагмаа, Г.Болорчимэг – 30000

Тусгай байр: С.Намжилмаа, Б.Өлзийбаяр, Н.Нарантуяа – 15000

**Гурав.** 3 сарын 5-ны 15.00 цагаас Соёлын төвд: “Сумын 2019 оны Манлай ээж” өргөмжлөлт Улаантуг багийн өндөр настан **Цэвэлсүрэнгийн Баясгалангийн** нэрэмжит “**Дуулах өдөр-дуун цэнгүүн**”-ийг ахмад настнуудын дунд зохион байгуулж “Дуучин ахмад”, “Бүжигчин ахмад”-ыг шалгаруулсан.

**Дуучин ахмад:** 1-р байр Ш.Дорж

2-р байр Н.Гачил

3-р байр Д.Цэцэгмаа

**Бүжигчин ахмад:** 1-р байр Б.Туул

2-р байр Л.Наранцэцэг

3-р байр Д.Баярмаа нар тус тус шалгарч Ц.Баясгалан болон түүний үр хүүхдүүд шагналын санг ивээн тэтгэсэн.

Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс ахмад наснуудаа хүндэтгэн угаж улаан дарсаар дайлж, нийт ирсэн ахмад, эмэгтэйчүүдэд амьд сарнай бэлэглэсэн.

**Дөрөв.** 03 сарын 06-ны өдрийн 12 цагаас сургуулийн өмнөх талбайн цасыг эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгчид, Соёлын төвийн ажилтан нар хамтарч цэвэрлэж “**Цэвэр агаар-Идэвхтэй хөдөлгөөн**” уралдаант тэмцээнийг 4 баг, 4 хорооллын 19-54 насныханы дунд зохион байгуулан “Дүүрэн Шарга” ХХК ивээн тэтгэлээ.



1-р байр Булаг хороолол, 2-р байр Шанд хороолол, 3-р байр Баянгол баг



**Тав.** 03 сарын 06-ны өдрийн 19 цагаас Соёлын төвд: “**Бүсгүйчүүд**” уралдаант тэмцээнийг 4 баг, 4 хорооллын дунд зохион байгуулж “Монгол Ардын Нам” ивээн тэтгэлээ.

1-р байр Ургац хорооллын “Улаан сарнай” баг

2-р байр Рашаант хорооллын “

3-р байр Хамтын хүч багийн “Хүчирхэг хүүхнүүд” баг



**Зургаа.** 03 сарын 07-ны өдрийн 10.00 цагаас Соёлын төвд:

“**Сумын 2019 оны өргөмжлөлт ээж**”-үүдийн алдар тэмдэглэх ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. “**Буянтай ээж**”-ээр Хамтын хүч багийн өндөр настан **Жамбалын Жогвоон**, “**Манлай ээж**”-ээр Улаантуг багийн өндөр настан **Цэвэлсүрэнгийн Баясгалан** нар өргөмжлөгдлөө. Уламжлалт ёсоор ёслолын арга



хэмжээг зохион байгуулж 2 ээжийн үр хүүхэд, садан төрлийн дунд “Та та тунгаа” найрсаг тэмцээнийг зохион байгуулсан.

1-р байранд Амартүвшин, Бадамханд /20000 төг/

2-р байранд Баярсайхан, Өнөрцэцэг /10000 төг/ нар тус тус орсон.

Мөн “Манлай ээж” Ц.Баясгалангийн нэрэмжит “Дуучин ахмад” тэмцээнд 1, 2-р байр эзэлсэн Ш.Дорж, Н.Гачил, “Бүжигчин ахмад” тэмцээнд 1-р байр эзэлсэн Б.Туул нар ая дууны мэндчилгээ дэвшүүлэв.

**17.00** цагаас : “**Бүсгүй ертөнц**” арга хэмжээний хүрээнд баг, хорооллууд баярын ширээ засаж, “**Шилдэг эмэгтэй**” шагнал гардуулах ёслолын арга хэмжээ явагдлаа.

“**Шилдэг ээж**”-ээр Улаантуг багийн өндөр настан М.Батсүх

“**Шилдэг сэхээтэн эмэгтэй**”-ээр ЗДТГ-ын Нийгмийн даатгалын улсын байцаагч Б.Хорлоожав

“**Шилдэг бүтээлч эмэгтэй**”-ээр Баянгол багийн малчин С.Оюунцэцэг

“**Шилдэг ажилтан эмэгтэй**”-ээр Бүрэн дунд сургуулийн тогооч Ц.Отгонбаяр

“**Шилдэг тариаланч эмэгтэй**”-ээр Баянгол багийн тариаланч Д.Даваажав

“**Шилдэг малчин эмэгтэй**”-ээр Улаантуг багийн малчин С.Сарантуяа

“**Шилдэг бизнесмен эмэгтэй**”-ээр “АМО-Шарга” ХХК-ий захирал Б.Оюунгэрэл нар тус тус шалгарлаа.



Шилдэг 7 эмэгтэйн шагналыг аймгийн ИТХ-ын төлөөлөгч С.Сүхбаатар бүрэн хариуцаж, шагналын санг даасан болно.

Сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс 2018 онд “Аймгийн аварга саальчин” болсон Баянгол багийн малчин С.Оюунцэцэгт хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл хадгалуулж, 1 эмэгтэйг азтангаар шалгаруулж Н.Цогзолмаа тодорч МУСТА Б.Чулуунчимэгийн хамгийн сүүлийн үеийн уран бүтээлийн цомог болох “Бүсгүй ертөнц” цомгоор шагналаа.



Мөн уг арга хэмжээний үеэр 4 баг, 4 хорооллын дунд “**Карaoke**” тэмцээнийг “АМО-Шарга” ХХК ивээн тэтгэж явуулсан.

1-р байранд Рашаант хороолол

2-р байранд Шанд хороолол

3-р байранд Ургац хороолол

УИХ-ын гишүүн Ш.Раднаасэдийн “Манжуур явах эрхийн бичиг”-ийг азын сугалаагаар тодорүүлж өгсөн ба Б.Норжингаамаа, Г.Ууганцэцэг, Б.Хөгжилт нар тодорлоо.

**Долоо. 3 сарын 08-ны өдрийн 19.00** цагаас соёлын төвд “**Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай**” азын суудал, хөгжөөнт тэмцээнтэй цэнгээнт бүжгийг зохион байгуулсан.

ЗДТГ-аас зохион байгуулсан тэмцээнд Д.Наранцэцэг

ЭМТ-өөс зохион байгуулсан тэмцээнд Б.Баялагмаа

Хүүхдийн цэцэрлэгээс зохион байгуулсан тэмцээнд В.Оролмаа нар тус тус тэргүүлж, мөнгөн шагналаар шагнуулсан.



Мөн уг арга хэмжээний үеэр “Тахийн Шарга” ХХК-аас “1 минут-100000” уралдаант тэмцээнийг зохион байгуулж О.Амгалан ялагчаар тодорсон.



Соёлын төвөөс азтай үзэгчийг шалгаруулж: 10000 төгрөгийн азтангаар Н.Нарантуяа, Г.Болорцэцэг, Ж.Цэцэгмаа нар, 20000 төгрөгийн супер азтангаар Ариунбуян шалгарсан бол, “Тахийн Шарга” ХХК-аас тодруулсан азтай үзэгчээр өндөр настан Б.Бурмаа, Го.Гантулга нар тодорч тус бүр 10000 төгрөгийн азтан болсон.

**Мэдээллийг нэгтгэсэн: ДАШБХ мэргэжилтэн Д.Ончимэг**